

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН МЭДЭЭ**

2024 оны 12 дугаар сарын 24

Улаанбаатар хот

Д/д	Тайлан	Хугацаа												
1	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн нэгдсэн системээр бүртгэн шилжүүлсэн нийт өргөдөл, гомдол – 3662	2024.01.02 2024.12.23												
	<table style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 80%;">Шийдвэрлэх шатандаа байгаа -</td> <td style="text-align: right;">31</td> </tr> <tr> <td>Хугацаандаа шийдвэрлэсэн -</td> <td style="text-align: right;">3624</td> </tr> <tr> <td>Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн -</td> <td style="text-align: right;">7</td> </tr> </table>		Шийдвэрлэх шатандаа байгаа -	31	Хугацаандаа шийдвэрлэсэн -	3624	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн -	7						
Шийдвэрлэх шатандаа байгаа -	31													
Хугацаандаа шийдвэрлэсэн -	3624													
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн -	7													
2	Иргэний талд шийдвэрлэсэн -	1890												
	Боломжгүй тухай хариу өгсөн –	1692												
3	Бусад –	45												
	Шийдвэрлэлт -	98%												
2	Хэлтэс, нэгжид хуваарилагдсан өргөдөл, гомдлын тоо:	2024.01.02 2024.12.23												
	<table style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 80%;">Захиргаа, удирдлагын хэлтэс –</td> <td style="text-align: right;">257</td> </tr> <tr> <td>Тээврийн бодлого, судалгааны хэлтэс–</td> <td style="text-align: right;">1862</td> </tr> <tr> <td>Санхүү, аж ахуйн хэлтэс –</td> <td style="text-align: right;">37</td> </tr> <tr> <td>Зорчигч, тээврийн хэлтэс –</td> <td style="text-align: right;">164</td> </tr> <tr> <td>Хяналт шалгалтын хэлтэс –</td> <td style="text-align: right;">1287</td> </tr> <tr> <td>Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэс –</td> <td style="text-align: right;">23</td> </tr> <tr> <td>Бүртгэл, техник, технологийн хэлтэс –</td> <td style="text-align: right;">32</td> </tr> </table>		Захиргаа, удирдлагын хэлтэс –	257	Тээврийн бодлого, судалгааны хэлтэс–	1862	Санхүү, аж ахуйн хэлтэс –	37	Зорчигч, тээврийн хэлтэс –	164	Хяналт шалгалтын хэлтэс –	1287	Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэс –	23
Захиргаа, удирдлагын хэлтэс –	257													
Тээврийн бодлого, судалгааны хэлтэс–	1862													
Санхүү, аж ахуйн хэлтэс –	37													
Зорчигч, тээврийн хэлтэс –	164													
Хяналт шалгалтын хэлтэс –	1287													
Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэс –	23													
Бүртгэл, техник, технологийн хэлтэс –	32													
3	Гомдол –	2094												
	Хүсэлт –	1147												
3	Санал –	401												
	Талархал –	10												
3	Зөрчил-	10												
	Мэдэгдэл-	0												
Зөрчлийн тоон үзүүлэлт														
4	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	203												
5	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	189												
6	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	577												
7	Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	1												
8	Дундаж хоног	6 хоног 9 цаг 18 минут												
9	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	7												

• Тус газрын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн UB ERP нэгдсэн системд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт **3662** өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн 3631, шийдвэрлэх шатандаа байгаа 31 өргөдөл, гомдол байна.

Иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу зохион байгуулан хэрэгжүүлсэн ажлын талаар:

Нийт ирсэн өргөдөл, гомдлын 2094 буюу 57.1 хувь “Гомдол” байгаагаас Тээврийн бодлого, судалгааны хэлтэст-1003, Хяналт шалгалтын хэлтэст-911, Зорчигч, тээврийн хэлтэст-112, Санхүү, аж ахуйн хэлтэст-23, Захиргаа, удирдлагын хэлтэст-11, Бүртгэл, техник, технологийн хэлтэст-17, Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэст-17 гомдол ирсэн байна.

Автобусны тоо, чиглэл нэмэх, өөрчлөх, маршрутын тухай-1103, нийтийн тээврийн үйлчилгээний салбарын үйл ажиллагааны тухай-390, автобусны жолоочийн үйлчилгээний соёлын тухай-124, автобусны цагийн хуваарийн тухай-55 гомдол байна.

Гомдол мэдээллийн дагуу Сар шинийн баяр, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр “Мартын-8”, Бурхан багшийн Их дүйчин өдөр, “Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”, “Хүүхдийн баяр” зэрэг 5 удаагийн бүх нийтийн баярын өдрүүдээр нийтийн тээврийн хэрэгслийн цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан, мөн нийслэл хотод зохион байгуулагдсан нийтийг хамарсан арга хэмжээ Сар шинийн баярыг угтаж “Хүчит шонхор” хүнсний захын зүүн талын замын хөдөлгөөний чиглэлийн өөрчлөлттэй холбоотойгоор 3 чиглэл, 12 дахь жилдээ зохион байгуулагдаж буй “POWER Expo & Festival XII” арга хэмжээтэй холбоотой 1 чиглэл, “Улаанбаатар Марафон” гүйлтийн арга хэмжээ холбоотой 37 чиглэл, “Тэнгэр” олон улсын фестиваль Хүй долоон худагт зохион байгуулагдсантай холбоотой 1 чиглэл, Байгальд Чангаар Гэрэлт | Be LOUD, shine at nature уриатай, Nature, Arts & Crafts, Books сэдэв дор зохион байгуулагдсан “Монголын анхны байгаль дахь хүүхдийн эрхийн төлөөх фестиваль” зохион байгуулагдсантай холбоотойгоор 2 чиглэл, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Цагдаагийн ерөнхий газраас энэ оны 06 дугаар сарын 01-ний өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд “Хүүхэд таны төлөө” арга хэмжээ зохион байгуулсантай холбоотой 2 чиглэлийн өөрчлөлтүүдийг боловсруулж нэгдсэн даалгаварт тусгаж ажилласан.

Гомдол мэдээллийн дагуу шинээр нээж, өөрчлөлт оруулсан чиглэлүүд:

1.Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн 292 иргэдийг хамруулсан эрэлтийн судалгааг цахимаар явуулж, ирүүлсний үндсэн дээр 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/46 дугаар тушаалаар Х:18 “Улаанбаатар (Дүнжингарав худалдааны төв)-Багахангай” чиглэлийг шинээр нээж батлуулсан.

2.2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Ү:18 “Ганхийц-Цамбагарав” чиглэлийн замналд өөрчлөлт оруулахаар газар дээр нь ажиллан зорчигчдоос эрэлтийн судалгаа авч, судалгааны дүгнэлтийг үндэслэн 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр А/36 дугаартай тушаалаар тус чиглэлийн замналыг Ү:18 “Ган хийц-Цамбагарав-Мотобуудлага спортын төв” болгон өөрчлөлт оруулсан.

3.Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Засаг даргын тамгын газартай хамтран тус хорооны иргэдээс шинээр нээж чиглэлийн эрэлтийн судалгааг авсны үндсэн дээр 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/52 дугаартай тушаалаар Х:21 “Ногоон толгойн эцэс-Жаргалант (Партизан)-5 шар” чиглэлийг шинээр нээсэн.

4.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудыг Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шинээр баригдсан “Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор” барилгад нүүлгэн шилжүүлэх шийдвэр гарсантай холбоотойгоор албан хаагчдын дунд явуулсан

судалгаанд үндэслэн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар 4:79 “Тачи-Гурвалжингийн гүүр-Яармагийн 1-р буудал, 4:80 “ХӨСҮТ-Үндэсний цэцэрлэгт хүрээлэн-Яармагийн 1-р буудал”, 4:81 “3,4-р хороолол-Нарны гүүр-Яармагийн 1-р буудал” чиглэлийг шинээр нээсэн.

5. Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс чиглэлийн төлөвлөлтийг оновчтой боловсруулах, чиглэлийн давхцалыг багасгах зорилгоор 111 чиглэлийн дайран өнгөрөх 1170 зогсоолоор 70 хувиас дээш давхцалтай чиглэлүүдийг харьцуулан шинжилж, дүгнэх аргаар судалгааг хийж тайланг хэлтсийн дарга нарт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр танилцуулсан.

6. Тулгар төрийн 2233, Их Монгол Улсын 818 жил Ардын хувьсгалын 103 жилийн ой, Үндэсний их баяр наадмын өдрүүдээр нийтийн тээврийн зарим чиглэл үнэ төлбөргүй үйлчлэхээр бэлтгэл ажлаа хангаад байна.

2024 оны 07 дугаар сарын 10,11,12,13-ний өдрүүдэд дараах 7 чиглэлд нийт 32 тээврийн хэрэгслээр өглөө 07:20 цагаас орой 21:00 цаг хүртэл үйлчилнэ. Үүнд:

- БЭ:1 “Мишээл сити- Төв цэнгэлдэх хүрээлэн”
- БЭ:2 “Дүнжингарав худалдааны төв- Төв цэнгэлдэх хүрээлэн”
- БЭ:3 “Нарантуул худалдааны төв-Төв цэнгэлдэх хүрээлэн”
- БЭ:4 “Вокзалын 1000 машины зогсоол- Төв цэнгэлдэх хүрээлэн”
- БЭ:5 “Давааны зөрлөг-Хүй 7 худаг
- Хүй7:1 “Төв цэнгэлдэх хүрээлэн-Хүй 7 худаг”
- Хүй7:2 “МУБИС-Хүй-7 худаг”

7. Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх зорилгоор маргааш буюу 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байна.

-Х:19 “Чингис хаан нисэх буудал-Сүхбаатарын талбай”

-Х:20 “Чингис хаан нисэх буудал-Буянт-Ухаа спорт цогцолбор” чиглэлүүдэд 06:20 цагаас 22:30 цагийн хооронд автобус явж эхэлнэ.

-Х:19 “Чингис хаан нисэх буудал-Сүхбаатарын талбай” чиглэлд том хүн 15000 төгрөгөөр, хүүхэд 7000 төгрөгөөр, Х:20 “Чингис хаан нисэх буудал-Буянт-Ухаа спорт цогцолбор” чиглэлд том хүн 10000 төгрөгөөр, хүүхэд 5000 төгрөгөөр мөн картаар үйлчлүүлэх боломжтой.

8. 2024оны 08 дугаар сарын 3,4-ний өдрүүдэд Хүй долоо худагт "Даншиг наадам-Хүрээ цам 2024" наадам зохион байгуулагдана. Үүнтэй холбоотойгоор нийтийн тээврийн хоёр чиглэлд 10 автобус иргэдэд үйлчилнэ.

Тодруулбал:

08:00-22:00 цагийн хооронд

-“МУБИС- Хүй долоон худаг”;

-“Төв цэнгэлдэх- Хүй долоон худаг” гэсэн хоёр чиглэлд нийтийн тээвэр иргэдэд үйлчилнэ.



9. Иргэдийн санал хүсэлтийн дагуу нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тус газрын даргын А/101 дүгээр тушаалаар Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороонд байрлах Шарга Морьт завсар /баруун/ зогсоолд 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн тухайн зогсоолоор дамжин өнгөрдөг чиглэлийн автобуснууд зогсохоор боллоо.

Үүнд:

- Х:1 – Санзайн эцэс – Их Тамир – Зунжин худалдааны төв – 7 буудал
- Х:2 – Шарга морьт – Зунжин худалдааны төв – 7 буудал
- ЗУ:3 – Баянбулаг – Сүхбаатарын талбай

10. 2024-2025 оны хичээлийн шинэ жилд ерөнхий боловсролын 70 сургуулийн 67 чиглэлд 72 автобус, хувийн сургуулийн 145 автобус сурагчдад үйлчилж байна.

10. Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/107 дугаар тушаалаар Д:10 "Офицеруудын ордон - Баганат өргөө хороолол - Шархад - 158-р сургууль" чиглэлийг шинээр нээж, дунд багтаамжийн автобусаар 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс үйлчилгээнд явуулж эхэлсэн.

11. Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/106 дугаар тушаалаар Д:9 "Хан-Уул дүүргийн 8-р хорооны эцэс-Яармаг-Англи сургууль" чиглэлийн замналыг шинээр нээж, дунд багтаамжийн автобусаар 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс үйлчилгээнд явуулж эхэлсэн.

Автобусны жолооч нарын үйлчилгээний соёлын талаар ирсэн гомдол мэдээлэл нэлээдгүй байгаад анхаарч Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо, Тээврийн Цагдаагийн алба, тус газрын хамтарсан 2024 оны 04 дүгээр сарын 17-ний өдөр баталсан удирдамжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 16-ний өдрийг дуустал хугацаанд хуваарийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж, байгууллагын инженер техникийн 78 ажилтан, 1517 жолооч, нийтийн тээврийн такисны үйлчилгээ эрхлэгч 6 аж ахуйн нэгжийн 72 жолооч, 12 шалгах механик нийт 1714 хүнийг хамруулан 25 удаагийн сургалтыг зохион байгуулав.



2024 оны 09 дүгээр сарын 16-ний өдөр "Галын аюулгүй байдлыг хангах нь" сэдэвт сургалт болсон. Сургалтыг Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах 26-р ангийн II хэсэг, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-аас хамтран зохион байгуулав.



Жолооч нар бэлэн мөнгө авч байгаа мэдээллийн дагуу Автотээврийн хяналтын улсын байцаагч нар ажиллаж Нийтийн тээврийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор тус газрын даргын 2024 оны “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний хөлс төлөлтийн байдалд хяналт тавих шалгалтын ажлын удирдамж”-ийг батлуулан 2024 оны 01 дүгээр сарын 10-ний өдрөөс эхлэн 5-н шар, офицеруудын ордон, 120 мянгат, 7 буудал зэрэг 4 байршлуудад 11 Автотээврийн хяналтын улсын байцаагч болон 8 шалгагч нар зорчигчийн хөлс төлөлтөд хяналт шалгалт хийж ажиллав. 2024 оны 01 дүгээр сарын 10-ний өдрөөс өссөн дүн, давхардсан тоогоор нийт 2,580 чиглэлийн их болон дунд багтаамжийн 71,351 тээврийн хэрэгсэл, 178,901 зорчигчдыг шалгаж, бэлэн мөнгөөр зорчсон, U money картын үлдэгдэл хүрэлцээгүй, зорчих картгүй, зорчих хөлс төлөөгүй зэрэг нийт 36,403 зөрчил илрүүлж, зөрчлийг газар дээр нь арилгуулж, 142,498 зорчигчийг нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс татгалзан, зорчуулахгүй буулгаж, Easy pay /изи пей/ посын цэнэглэлтээр 2,149,940,000 мянган төгрөгийн цэнэглэлт хийж, Зөрчлийн тухай хуулийн 14.6.1 дэх заалтын дагуу бэлэн мөнгөөр зорчсон 51 иргэнд торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа.



Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, маршрут, цагийн хуваарь мөрдөлт, баримт бичгийн бүрдэл, гэрээний үүргийн биелэлт, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад хяналт тавин ажиллаа. Зөрчлийг арилгуулах зорилгоор давхардсан тоогоор улсын байцаагчийн 60 заалт бүхий 28 албан шаардлага, 1466 тээврийн хэрэгсэлд 3846 заалт бүхий 225 техникийн дүгнэлт гаргасан.

Автотээврийн хяналтын 11 улсын байцаагч 18 аж ахуйн нэгжийн өглөөний эх авалтаар 2015 тээврийн хэрэгсэл хамрагдсанаас 928 зөрчил илрүүлж (Дугуйн хээ-7, дулаацуулга-1, шил-10, сандал, түшлэгний бүрэн бүтэн байдал-9, Цахилгаан тоноглол гадна тал-10, чиглэлийн хаяг-4, хаалга-50, галын хорын жин-78, заалны гэрэл-9, заалны дулаацуулга-1, замналын зураг-7, эмблем-7 дотор цэвэрлэгээ-26, суудлын бүрээс бохир-11, суудлын бүрээсгүй-72, мэргэшсэн үнэмлэхгүй-29, ажлын хувцасгүй-65, ерөнхий өнгө үзэмжгүй-4, гадна дотор цэвэрлэгээ дутуу-88, суудлын бэхэлгээгүй-7, камерын үйл ажиллагаа алдагдуулсан-153), илэрсэн зөрчлийг арилгуулахаар Автотээврийн хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч, Автотерминал трейд ХХК, Трансбус ХХК, Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-уудад тус бүрт зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр бүлгийн 6 дэх хэсгийн 9 дүгээр заалтыг үндэслэн 250 нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр торгож арга хэмжээ тооцож ажиллав.

Иргэдээс ирүүлсэн гомдол, хүсэлтийн дагуу Автотээврийн хяналтын улсын байцаагч нар ажиллаж нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 198 аж ахуйн нэгж байгууллага, 692 иргэн, автобусны жолооч нарын гаргасан 890 зөрчилд 102,190,000 сая төгрөгийн торгууль шийтгэврийн хуудсаар тавьж ажиллалаа.

Гомдлын дагуу боломжгүй тухай хариу өгсөн 963, гомдол гаргагчид мэдээлэл өгч иргэн талд шийдвэрлэсэн 1086, шийдвэрлэх шатандаа байгаа 17 гомдол байна.

Иргэдээс ирүүлсэн саналын дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын талаар:

Нийт ирсэн өргөдөл, гомдлоос 401 буюу 10,9 хувь “Санал” байгаа нь Тээврийн бодлого, судалгааны хэлтэст-274, Хяналт шалгалтын хэлтэст-99, Зорчигч, тээврийн хэлтэст-14, Бүртгэл, техник, технологийн хэлтэст-8, Санхүү, аж ахуйн хэлтэст-3, Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэст-2 санал ирсэн байна.

Нийслэл Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны 02 дугаартай Зөвлөмжийн дагуу нийтийн тээврийн чиглэлийн давхцалыг бууруулах хүлээгдлийн хугацааг багасгах ажлын хүрээнд нийтийн тээврийн чиглэлийг шинэчлэн баталж 74 чиглэлд 1075 автобусаар үйлчилгээг 2024 оны 01 дүгээр сарын 20-ний өдрөөс хэрэгжүүлсэн. Ингэхдээ 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн албан бичгээр Нийслэлийн 6 дүүрэг, Замын хөдөлгөөний удирдлагын төв, Нийслэлийн замын хөгжлийн газар, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад чиглэлийн дахин төлөвлөлтөд тусгах санал авсан.

Чиглэлийн тээврийн хэрэгслийн 209 зогсоолын мэдээллийн самбарт дахин төлөвлөлтийн ерөнхий мэдээллийг байршуулснаас гадна иргэд, олон нийтэд мэдээллийг цахимаар хүргэх зорилгоор “Imar.mn” цахим сайт, аппликейшнд дамжин суултын мэдээллийг байршуулсан.

Түүнчлэн “Аргун” ХХК өөрийн аппликейшнд нийтийн тээврийн чиглэлийн мэдээллийг оруулж, нийтийн тээврийн хэрэгслүүдэд “QR” бүхий стикерийг байршуулсан.

Нийтийн тээврийн чиглэлийн дахин төлөвлөлтийг хийх хэрэгцээ, шаардлага болон холбогдох мэдээллийг Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол буюу 2024 оны 01 дүгээр сарын 10-ний өдрөөс хойш сурталчилсан.

Нийслэлийн гол гудамж зам болох Энхтайваны өргөн чөлөө, Чингэлтэйн өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөөнөөс Наадамчдын зам, Их тойруугийн гудамж, Нарны зам, Хүннүгийн гудамжаар нийт 6 чиглэлд 375 автобус, дээрх 6 үндсэн чиглэлийг холбосон 8 тойрог чиглэлд 92 автобус, бусад гудамж замуудаар үйлчлэх 40 богино эргэлтийн чиглэлд 494 автобус, хот орчмын 15 чиглэлд 89 автобус, их багтаамжийн автобус явах боломжгүй хотын захын хорооллуудаар үйлчилгээ үзүүлэх дунд багтаамжийн 5 чиглэлд 25 автобус үйлчилгээнд ажиллахаар төлөвлөсөн.

Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Нийтийн тээврийн газрын холбогдох хэлтэс нь дүн шинжилгээг хийж мэдээллийг эрх бүхий албан тушаалтанд тухай бүр танилцуулж, Нийслэлийн Засаг даргаас чиглэл авч 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн үндсэн гол гудамж, замуудаар үйлчилгээ үзүүлж буй үндсэн 6 /М:/ чиглэл, Хот орчмын болон үндсэн дамжин суултын 28 чиглэл, нийт 34 чиглэлд 625 тээврийн хэрэгслийг хэвээр үлдээж, хуучин 71 чиглэлийг /Ч:/ сэргээж нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

2024 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс мөрдөж буй нэгдсэн даалгавраар 105 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ ажлын өдөр 05:30-00:00 хооронд 1091, амралтын өдөр 7:00-23:00 цагийн хооронд 870 тээврийн хэрэгслээр үйлчилж байна. Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд 12 аж ахуйн нэгжийн 29 чиглэлийн гаралтын тоог нэмэгдүүлэн ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/110 дугаар захирамжаар 150 тээврийн хэрэгслийн багтаамжтай Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 3 дугаар баазын үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор Наадамчдын замаар зорчих тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх, сул километрийг багасгах үүднээс зарим чиглэлийг шилжүүлэх ажил хийгдэж байна.

Нийтийн тээврийн чиглэлийн дахин төлөвлөлтийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор зорчилтод зарцуулах хугацаа 0:16 минутаар багассан. Цаашид өдөрт үйлчлэх тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэн хүлээгдлийн хугацааг бууруулахаар төлөвлөсөн.

Иргэдээс ирүүлсэн саналын дагуу шинээр өөрчлөлт оруулсан чиглэлүүд:

1.Газрын даргын 2024 оны 05 дугаар 31-ний А/74 нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийн замнал хаах тухай 2024 оны 06 дугаар 07-ны А/75 Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн замналд өөрчлөлт оруулах тухай. 2024 оны 06 дугаар сарын 11-ний А/76 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийн замналд өөрчлөлт оруулах тухай


2.2024 оны 06 дугаар сарын 12-ны А/77 Зуслангийн үйлчилгээ зохион байгуулах тухай /ЗҮ:01 "Гүнт Жигжид-Сүхбаатарын талбай".ЗҮ:2 "Гоодой-Сүхбаатарын талбай" ЗҮ:3 "Баянбулаг -Сүхбаатарын талбай"

3.2024 оны 06 дугаар сарын 12-ны А/78 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийн замналд өөрчлөлт орох тухай "Ш:1 5 шар-Офицеруудын ордон"Ш:2 Сүхбаатарын талбай-Нисэх"Ш:3 Зунжин Сүхбаатарын талбай "


тушаалууд ирүүлсэн. 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл мөрдөгдөх нэгдсэн даалгавраар ажлын өдөр 1042 тээврийн хэрэгсэл амралтын өдөр 846 тээврийн хэрэгсэл шугамын үйлчилгээнд ажиллаж, Зуслангийн 3 чиглэл. Шөнийн тээврийн 3 чиглэл нээгдсэн.

4.Нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлтээр орж ирсэн дунд багтаамжийн Hyundai County маркийн 19 хүний суудалтай автобусаар үйлчлэхэд бэлэн боллоо. Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн гэр хорооллын дундуур шинээр тавигдсан замаар дараах маршрутын дагуу ирэх даваа гариг буюу 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс дараах долоон чиглэлд үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:


Д:8 "Тахилт зам анги - Толгойт – 21-р хороолол – 5 шар - Товчоо"




Д:7 "ГАЧУУРТЫН ЭЦЭС – АРЦАТЫН АМ"




Д:6 "ШАР ХООЛОЙН АМ – ГАЧУУРТЫН ЭЦЭС"




Д:5 "ХҮЧИТ ШОНХОР – ЗУРАГТЫН ХУУЧИН ЭЦЭС – ЭХ НЯЛХАС"



Д:4 "СХД 31-Р ХОРОО - ХАЙРХАНЫ ЭЦЭС – 11-Р БАЙР"



Д:2 "ДЭНЖИЙН 1000-САМБАЛХҮНДЭВИЙН ГУДАМЖ - 149-р сургууль"




Д:1 “ШАРХАД – ХАНГАМЖ - БОТАНИК”



5. Нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлтээр орж ирсэн дунд багтаамжийн Hyundai County маркийн 19 хүний суудалтай автобусаар үйлчлэхэд бэлэн боллоо. Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн гэр хорооллын дундуур шинээр тавигдсан замаар дараах маршрутын дагуу 06 дугаар сарын 24-ний өдрөөс дараах долоон чиглэлд үйлчилгээ үзүүлнэ.

Үүнд:

Д:8 “Тахилт зам анги - Толгойт – 21-р хороолол – 5 шар - Товчоо”




6. Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/153 дугаар тушаалын дагуу "Зорчигч тээвэр тав" ОНӨААТҮГ-ын Д:7 Гачууртын эцэс-Арцатын ам / Дунд оврын/ чиглэлийг зогсоож, уг чиглэлийн замналыг Д:6 Шар хоолойн ам-Гачууртын эцэс / Дунд оврын/ чиглэлийн маршрут, тээврийн хэрэгсэлтэй нэгтгэн өөрчилж, 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс

талбай-Натур худалдааны төв-Жанжин клуб чиглэлийн замналд өөрчлөлт орж, 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс мөрдөн ажиллаж эхэлсэн.

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны дугаар сарын -ний өдрийн А/..... дүгээр тушаалын дугаар хавсралт


Ү:30 “СҮХБААТАРЫН ТАЛБАЙ – НАТУР ХУДАЛДААНЫ ТӨВ - ЖАНЖИН КЛУБ”




Тайлбар :		
Эргэлтийн урт:	17.8 км	Жанжин клуб
Эргэлтийн хугацаа:	54	Чулуун овоо
Зогсох буудлын тоо:	26	2-ын буудал
Дайран өнгөрөх уулзварын тоо:	5	Хөдөлгөөний чиглэл
		Эцсийн зогсоол
		Хоёр чиглэлдээ зогсдог зогсоол
		Нэг чиглэлдээ зогсдог зогсоол
		Гудамжны нэр
		Газрын налууугийн градус /уруу/
		Газрын налууугийн градус /өгсүүр/
		Гэрлэн дохио
		Гүүр
		Аюулгүйн тойрог

Иргэдээс ирүүлсэн саналын дагуу боломжгүй тухай 235 иргэнд хариу өгч, 159 иргэнтэй санал солилцож иргэн талд шийдвэрлэж, шийдвэрлэх шатанд байгаа 7 санал байна.

2018-2024 оны санал, гомдлын харьцуулсан дүн мэдээ




Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны талаар:



- Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хоног 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 6 хоног 09 цаг 18 минут байгаа нь нийслэлийн дундаж хоногт багтаан шийдвэрлэж байгаа үзүүлэлттэй байна.

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад гаргасан зөрчлийн талаар



- 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 970 зөрчил тооцогдсон байгаагаас өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил 577, өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил 189, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил 203, буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил 1, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-7 байна.

- Мөн байгууллагын хүний нөөцийн чиглэлээр ирсэн 188 өргөдөл, гомдлыг цаг тухай бүр шийдвэрлэн ажилд авах, чөлөөлөх, чөлөө олгох, тусламж дэмжлэг үзүүлэх чиглэлээр Газрын даргын 164 тушаал гарч өргөдөл, гомдлыг шийдвэрлэн ажиллалаа.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03/226 дугаартай зөвлөмжид тусгагдсан, анхаарч ажиллах шаардлагатай заалтуудыг хэрэгжүүлэх Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Газрын даргаар батлуулж 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн шуурхай хуралдаанд нэгдүгээр улиралд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шалтгаан нөхцөлийг тодорхойлон, хэлэлцүүлж цаашид иргэний хандалтын төрөлд анхаарч илүү нарийвчилсан дүн шинжилгээг хийж ажиллах чиглэл өгөв.

- Өглөөний шуурхай хуралдаанд “Бусад” байдлаар шийдвэрлэгдэж зөрчил тооцогдсон 5 өргөдөл, гомдлыг албан хаагч тус бүрээр гаргаж танилцуулан хэлтсийн дарга нарт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцад зөрчил тооцуулахгүй ажиллах чиглэл хүргүүлэв.

- Тухайн 7 хоногт шийдвэрлэгдсэн, зөрчил тооцогдсон албан хаагч тус бүрээр дүн мэдээг гарган 5 дахь өдрийн шуурхай хуралдаан бүрд танилцуулан ажиллаж байна.

- Тус газарт оны эхнээс 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 3662 өргөдөл, гомдол ирснээс 970 зөрчил тооцогдсон.

Үүнээс өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил 577, өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил 189, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил 203, буцаалтыг 3 хоногт багтаан шилжүүлээгүй зөрчил 1, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-7 байсан бөгөөд зөрчил гаргасан нийт албан хаагчид цаашид зөрчил гаргахгүй байх талаар анхааруулсан.

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

З.ЦЭВЭЭНДОРЖ

ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МЯГМАР

МЭДЭЭ ГАРГАСАН:

ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ГОМДОЛ ХАРИУЦСАН АХЛАХ АЖИЛТАН

С.БИЛГҮҮН